

“Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ
“Ил тод байдал сан” ТББ
Нээлттэй Нийгэм Форум
2013 оны 2-р сарын 20.

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТОВЧ МОНИТОРИНГ

Улсын болон орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын зарим асуудалд 2013 оны 2-р сард шуурхай мониторинг хийж энэ явцад цуглуулсан баримт мэдээллээ танилцуулж байна.

Бид төсвийн ил тод, нээлттэй байдлыг зохицуулсан эрх зүйн үндсэн баримт бичгээр “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” ба “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам” хоёрыг сонгож авсан юм. Учир нь тэдгээрт тодорхой цаглабараас гадна олон нийтэд хүргэх арга хэлбэр, зарим зохион байгуулалт, хариуцах эзэн зэргийг тогтоосон учраас шалгуур болгон ашиглах боломжтой байсан юм.

Ингэхдээ, дээрх хууль, журамд зааснаар оны эхний хоёр сард ил тод, нээлттэй болгохыг шаардсан дараах заалтууд хэрхэн хэрэгжсэнийг цахим сайт ба мэдээллийн самбарыг эх сурвалж болгон авч үзлээ.

“МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ”

9 дүгээр зүйл. Төсөв, санхүүгийн ил тод байдал

9.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

9.1.1. тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх:

9.1.1.а. тухайн жилийн төсвийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

“ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХАД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ”

Дөрөв. Мэдээллийг олон нийтэд хүргэх хугацаа, давтамж

4.2. Тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталж, хүчин төгөлдөр болсны дараа төсвийн захирагч дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:

4.2.2. төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төсвийг 7 хоногийн дотор;

4.2.3. төсвийн байгууллага өөрийн төсвөө 10 хоногийн дотор.

4.3. Төсвийн гүйцэтгэлийн тайланг эрх бүхий этгээд дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:

4.3.1. төсвийн байгууллага сар, улирлын тайланг сар, улирлын гүйцэтгэл гарснаас хойш 7 хоногийн дотор;

4.3.2. төсвийн байгууллага хагас жилийн тайланг 7 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор;

Нэг. ЦАХИМ САЙТ ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ

СҮХБААТАР ДҮҮРЭГ

Нэг ч заалтыг хэрэгжүүлээгүй.

Дүүргийн албан ёсны <http://www.sbd.gov.mn/> сайтад 2013 оны төсөв, оны эхний сарын тайлан одоог хүртэл тавигдаагүй. Харин төсвийн мэдээлэлд хамааруулж болох Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2012.12.24-

нд, Сүхбаатар дүүргийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө 2013.01.25-нд тус тус нийтлэгджээ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Нэг ч заалтыг хэрэгжүүлээгүй.

Дүүргийн албан ёсны <http://www.chingeltei.gov.mn>, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын <http://chingelteicouncil.mn> сайтуудад 2012 оны 12-р сарын 15-нд “Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн эхний сургалт Төсвийн тухай хуулийн талаарх сургалтаар эхэллээ” гэсэн мэдээнээс хойш төсвийн мэдээлэл ороогүй. Төсвийн гүйцэтгэл тавигдаагүй.

ХАН-УУЛ ДҮҮРЭГ

Нэг заалтыг хэрэгжүүлсэн, гэхдээ шууд биш.

“2013 онд Хан-Уул дүүргийн хороод төсвөө өөрсдөө хэлэлцэнэ” гарчигтайгаар “2013 оны 1 дүгээр сарын 24-нд нийтлэгдсэн танилцуулга дотор дүүргийн 2013 оны төсөв баталсан ИТХ-ын хуралдааны тогтоолыг оруулжээ. Гэхдээ үүнийг эрж олоход нэлээд түвэгтэй байв. Тус дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хороодод хуваарилсан тухай мэдээ, хэрхэн хуваарилсныг харуулсан хүснэгтийг бид өөр сайтаас олж авсан болно.

Бусад дүүргүүдтэй харьцуулахад төсвийн холбогдолтой илүү олон мэдээлэл түгээжээ. Гэхдээ хуучирсан. Хамгийн сүүлд нийслэлийн Хан-Уул дүүргийн 2012 оны төсөв баталсан тогтоол 2012.02.02-нд тавигдаж байв. “Хан-Уул” нэртэй үнэ төлбөргүй сонин гаргаж тараадаг ба хамгийн сүүлчийн дугаарт төсвийн тодорхой мэдээлэл ороогүй байна.

-Тус дүүргийн харьяа байгууллагууд нэг загварын цахим хуудсуудтай (жишээлбэл, <http://nd.khanuul.mn/home> - Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, <http://eruumend.khanuul.mn/home> - Эрүүл мэндийн хэлтэс, <http://khalamj.khanuul.mn/home> - Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, <http://soyol.khanuul.mn/home> - Соёлын төв, <http://police.khanuul.mn/home> - Цагдаагийн хэлтэс гэх мэт) боловч төсвийн мэдээлэл огт байхгүй.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

Нэг ч заалтыг хэрэгжүүлээгүй.

Дүүргийн албан ёсны <http://www.shd.mn> цахим сайт цоо шинээр хийгджээ. 2013 оны батлагдсан төсөв ба нэгдүгээр сарын гүйцэтгэлийн мэдээ тавигдаагүй.

Төсөв, санхүүгийн холбогдолтой хуучин мэдээлэл урьд нь байсан бол сайтаа шинэчлэхдээ бүгдийг устгасан гэж ойлгогдож байна. “Төсвийн байгууллага цахим хуудастай тохиолдолд тухайн цахим хуудас нь “байгууллагын төсөв” гэсэн цэстэй байна” гэсэн заалтыг бусад дүүргүүдийн нэгэн адил хэрэгжүүлээгүй.

БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Дүүргийн албан ёсны www.bzd.mn цахим сайт нь “Шинэчлэгдэж байна” гэсэн тайлбартайгаар хаалттай байсан тул дүгнэлт хийх боломжгүй.

НАЛАЙХ ДҮҮРЭГ

Нэг ч заалтыг хэрэгжүүлээгүй.

Дүүргийн албан ёсны <http://www.nad.ub.gov.mn/> цахим сайтын “Файл татах” буланд “Төсөв, санхүү” нэртэй хэсэг байгаа боловч 2011 оны төсвийн хуваарийг тавьснаас хойш шинэчлээгүй байна.

2013 оны батлагдсан төсөв тавигдаагүй.

Мөн Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2013.02.01-02.14-ны хугацаанд хийсэн ажлын товч тайланг шуурхай оруулжээ. Гэхдээ 1-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг тавигдаагүй.

БАГАНУУР ДҮҮРЭГ

Дүүргийн албан ёсны <http://baganuur.mn/> цахим сайт түр засвартай гэсэн тайлбартайгаар хаалттай тул дүгнэлт хийх боломж олдоогүй.

БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ

Нэг ч заалтыг хэрэгжүүлээгүй.

Дүүргийн төр, захиргааны сайтын хаяг - www.bagakhangai.ub.gov.mn 2013 оны батлагдсан төсөв ба оны эхний сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ ороогүй.

УЛААНБААТАР ХОТ

Зарим заалтыг хэрэгжүүлсэн.

2012 оны 12-р сарын төсвийн гүйцэтгэлийг 2013.01.10-нд байршуулсан нь төсвийн байгууллага сар улирлын тайланг гүйцэтгэл гарснаас хойш 7 хоногийн дотор ил тод болгох тухай Журмын заалтыг хэрэгжүүлсэн цорын ганц тохиолдол юм.

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын албан ёсны www.ulaanbaatar.mn сайтын “Нээлттэй мэдээлэл” цэс дор “Төсөв, нийгэм, эдийн засгийн зорилт” тусгай хэсэг байдаг ба сүүлийн саруудад төсвийн холбогдолтой дараах мэдээллүүдийг татаж авах боломжтойгоор байршуулжээ.

-Нийслэлийн орон нутгийн 2013 оны 01-р сарын орлогын мэдээ (2013-02-14)

-Нийслэл, дүүргийн 2012 оны 12-р сарын төсвийн гүйцэтгэл. (2013-01-10)

-Монгол Улсын засгийн газрын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2012-12-24)

-Нийслэлийн 2013 оны төсөв (2012-12-21)

-Нийслэл, дүүргийн 2012 оны 11-р сарын төсвийн гүйцэтгэл (2012-12-05)

-Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилт (2012-12-05) гэх мэт

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын <http://citycouncil.mn> цахим сайтад ИТХ-аас 2013 оны төсвийн баримт бичгүүдийг баталсан тогтоолуудыг байршуулжээ. Тухайлбал, 2012.12.13-нд “Нийслэлийн аудитын газрын 2013 оны төсвийг батлах тухай”, - 2012.12.29-нд “Нийслэлийн 2013 оны төсөв батлах тухай” - тогтоол, - 2012.11.28-нд 2012–2013 онд он дамжин хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг батлах тухай” тогтоолын төсөл.

Үүнээс гадна “Нээлттэй Улаанбаатар” (<https://www.facebook.com/ub.gov>) сайтад төсвийн талаар шуурхай мэдээ нийтлэгддэг нь дээрх www.ulaanbaatar.mn сайтад тавигдсан баримт мэдээллийн товчоо байдаг. Нийслэлийн Засаг даргын <http://www.mayor.mn/> сайт ажиллахгүй байна. Харин Нийслэлийн ИТХ-ын Ажлын албаны иргэний оролцооны хэлтсийн www.cityhall.gov.mn сайтад төсвийн үйл явцын мэдээлэл нийтлэгддэг.

Хоёр. МЭДЭЭЛЛИЙН САМБАР ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ

“Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-д төсвийн мэдээллийг ил тод болгоход мэдээллийн самбарыг чухалчилж нарийвчлан зохицуулсан байдаг.

5.1. Төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэхдээ мэдээллийн самбар, цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.

5.2. Цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран төсвийн байгууллага мэдээллийн самбарыг заавал ажиллуулна.

5.3. Журмын 5.2-т заасан мэдээллийн самбарын өргөн болон урт нь 1.5 метрээс багагүй хэмжээтэй байна. Мэдээллийн самбар нь байгууллагын гол хаалганы хажууд эсхүл хаалганы урдаас харсан хананд байрлаж, мэдээллийг шинэчлэх боломжтой байдлаар хийгдсэн байна. Самбарт тавигдах мэдээллийг энэ журмын 4.2-4.3-т заасан хугацаанд тогтмол шинэчилж байна.

Төсвийн анхан шатны байгууллагууд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-д заасан ил тод байдлын шаардлагуудыг (тухайн жилийн төсвийг жил бүрийн 01 дүгээр

сарын 10-ны өдрийн дотор, төсвийн байгууллага өөрийн төсвөө 10 хоногийн дотор, сар, улирлын тайланг сар, улирлын гүйцэтгэл гарснаас хойш 7 хоногийн дотор гэх мэт) заалтуудыг хэрэгжүүлэхэд мэдээллийн самбар чухал үүрэгтэй. Мэдээллийн самбар бол манай төр, захиргаа, төсвийн байгууллага бүрт маш олон тоотой байдаг, мэдээлэл хүргэх уламжлалт арга юм.

Бид нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн төсвийн зарим байгууллагаар орж мэдээллийн самбар байгаа эсэх, хэрвээ байгаа бол хууль, журмын дагуу байршуулсан эсэхийг үзэж бүртгэлээ.

СҮХБААТАР ДҮҮРЭГ



Тус дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн самбарт төсвийн мэдээлэл байхгүй.



Дүүргийн ЗДТГ-ын байрны нэгдүгээр давхарт байрласан “Мэдээллийн электрон дэлгэц”-д төсвийн мэдээлэл байхгүй.



Газрын албаны цахим мэдээллийн цэг хэмээх дэлгэц ямар мэдээлэлтэй төсвийн мэдээлэл байх эсэх тодорхойгүй.



“Иргэдийн шударга шүүх” төрийн бус байгууллагаас байрлуулсан самбар. Бид тус дүүргийн ЗДТГ, ИТХ, Газрын алба, Бүртгэл мэдээллийн тасаг, Цагдаагийн хэлтэс, “Сүхбаатар” эрүүл мэндийн нэгдэл, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсээр орж үзэхэд мэдээллийн самбарууд хангалттай олон, тэдгээрт тухайн байгууллагын үйлчилгээтэй холбоотой мэдээллүүд тавигдсан, харин төсвийн мэдээлэл тааралдаагүй болно.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ



Дүүргийн Засаг даргын тамгын газрын байрны үүдний хэсэгт байрласан самбарт төсвийн мэдээлэл тавигдаагүй. Самбарын байдал шаардлага хангахгүй байлаа.



Харин дүүргийн ИТХ-ын танилцуулга, сурталчилгааны самбар маш чанартай сайн хийгдсэн нь анхаарал татлаа.



Дүүргийн хүндэт самбарыг мөн адил дүгнэв.

ХАН-УУЛ ДҮҮРЭГ

Бидний орж үзсэн байгууллагуудад хууль журамд заасны дагуу мэдээллийн самбарт нэг ч төсвийн мэдээлэл тавигдаагүй байв. Үүнд Засаг даргын тамгын газар, татварын хэлтэс, дүүргийн прокурорын хэлтэс, Боловсролын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс (энэ хоёр хэлтэс дүүргийн ЗДТГ-ын байранд хамт байрладаг), Газрын алба, Биеийн тамир, спортын хороо, 15-р сургууль, 52-р сургууль, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, мөн 2, ба 3-р хорооны цогцолбор, 1-р хороо (тусдаа байргүй).



Дүүргийн ЗДТГ-ын байрны үүдэнд байрлсан мэдээллийн самбар. Төсвийн мэдээлэл байгаагүй.



Дүүргийн ИТХ-ын танилцуулга ба мэдээллийн самбар. Төсвийн мэдээлэл байхгүй.



Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн “Нээлттэй засаглал” самбарт төсвийн холбогдолтой мэдээлэл тавигдаагүй болно.



Дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн танилцуулгын самбарууд. 2007 оны төсвийн зарим мэдээллийг дурдсан ба шинэ мэдээлэл байхгүй.



Хан-Уул дүүрэг бол цахим дүүрэг.



Нэг цэгийн үйлчилгээний зааланд Интернэтэд холбогдсон хоёр компьютер байна. Харин түүгээр үзэх Хан-Уул дүүргийн khanuul.mn цахим сайт дахь төсвийн мэдээлэл маш бага байна.

Өнгөрсөн онд тус дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүд 200 шахам нийтийн зар мэдээний самбарыг хүлээлгэж өгч төр захиргаа, төсвийн байгууллагуудаас гадна хороодын Засаг дарга, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолборт байршуулжээ. Гэвч тэдгээрийн төсвийн мэдээллийг ил тод, нээлттэй болгоход ашиглаагүй, тийм журамтай эсэх нь тодорхойгүй.



Нийслэлийн дээр дурдсан дүүргүүдэд төсвийн мэдээлэл самбар нэгэнт байхгүй учраас “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-д заасан 3.1.1. эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, 3.1.2. дунд хугацааны бодлого, зорилт, стратеги, 3.1.3. үзүүлэх үйлчилгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, 3.1.4. төсвийн гүйцэтгэл, түүнд хийсэн аудитын дүгнэлт болон тэдгээрийн задаргааг ярих боломжгүй юм.

“Төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангах журам”-ын “5.6. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн самбарт байрлуулах энэ журмын 3.2-3.5-д заасан шаардлагыг хангах мэдээллийн бүтэц, агуулга, жишиг маягт зэргийг агуулсан үлгэрчилсэн заавар, зөвлөмжийг өөрийн албан ёсны цахим хуудас (www.mof.gov.mn) болон төсвийн ил тод байдлын цахим хуудас (www.iltod.gov.mn)-нд байршуулна” гэж заасны дагуу гурван маягттай (1.“Төсвийн байгууллагын зарлагын жилийн тайлан”, 2.“Төсвийн байгууллагын хөрөнгө оруулалтын жилийн тайлан, 3.Улсын орлого төвлөрүүлэгч байгууллагын жилийн тайлан) хавсралт гаргасан нь хангалтгүй, аль ч байгууллага ашиглахгүй байна.

2 дугаар сарын 25-ны дотор төсвийн байгууллагууд жилийн тайлангаа ил тод болгохоор Журам-д заасан боловч хэрэгжиж эхлээгүй байна.

Гурав. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-иар төрийн захиргаа, төсвийн бүх байгууллага үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авалтын мэдээллийг нэгдүгээрт, хуулинд заасан тодорхой хугацаанд өөрсдөө ил тод болгох, хоёрдугаарт, иргэд байгууллагууд хүсэлт тавьсан тохиолдолд долоо хоногийн дотор (шаардлагатай гэж үзвэл дахиад нэг долоо хоног сунгаж болно) гаргаж өгөх үүрэгтэй.

Бид урьд нь харьцангуй хаалттай байж ирсэн, төсвийн төлөвлөгөө, төсөл ба гүйцэтгэлийг хэлэлцэхэд төдийлөн яригдаад байдаггүй Засгийн газрын 29 тусгай сангийн 26(Хүний хөгжил сан, Нийгмийн даатгалын сан, Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан санг тусд авч судлахаар үлдээв) -г сонгон авч судалсан юм.

Нэг.

Тухайн тусгай сангуудын цахим сайт, хэрвээ тийм сайт байдаггүй бол харгалзах яам, газруудын цахим сайт руу нэвтэрч сангийн төсөв хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг байршуулсан эсэхийг шалгасан болно. Ингэхэд 2011 оноос хойш нэг ч сангийн

мэдээллийг тавиагүй байсан болно. Харин Засгийн газрын төсвийн ил тод байдлын www.iltod.gov.mn сайтад “Засгийн газрын тусгай сангууд 2011 онд” гэсэн товч танилцуулга, сангуудын 2010, 2011 оны орлого, зарлагын нэгдсэн хүснэгт бүхий хавсралт 2011 оны 1-р сарын 27-нд тавигджээ. Түүнээс хойшхи шинэ материал олдоогүй болно.

Хоёр.

Нэгэнт сангуудын мэдээлэл хаалттай буюу шинэчлэгдээгүй байсан учраас тэдгээрийг захиран зарцуулах эрх бүхий төсвийн ерөнхийлөн захирагчдын яамдын төрийн нарийн бичгийн дарга, эсвэл бие даасан ажлын албатай бол сангийн захирлуудад шууд хандаж 2011 ба 2012 онуудын эхний хагас жилийн төсөв хөрөнгийн орлого, зарцуулалтын тайланг төрийн бус байгууллага, судлаачид болон иргэд нягтлан үзэж дүгнэлт хийх боломж олгосон задаргаатайгаар хуульд заасан хугацаанд бичгээр өгөх, мөн дурдсан хугацааны тус сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, захиран зарцуулагчдын овог нэр, албан тушаалын нэрийг хавсаргахыг хүссэн албан бичиг явуулсан юм.

Хариу авсан байдлыг дараах хүснэгтээр харуулав.

№	Тусгай сангийн нэр	Харъяалах яам, агентлаг	Хариу ирүүлсэн	Тайлбар
1	Аялал жуулчлалын сан	Соёл, спорт аялал жуулчлалын яам (Урьд нь БОАЖЯ-нд хамаарч байсан)	Хуульд заасан хугацаанд 2012 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж ирүүлсэн. Харин зарцуулалтын задаргаа байхгүй.	Дахин албан бичиг явуулсан.
2	Байгаль хамгаалах сан	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	Огт хариу өгөөгүй.	Дахин албан бичиг явуулсан.
3	Эрсдэлийн сан	Сангийн яам	Тус сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн дүнг ирүүлсэн. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан, задаргаа байхгүй.	Хоёр удаа албан бичиг өгсөн болно.
4	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	Хариу өгөөгүй.	Дахин албан бичиг явуулсан.
5	Дархлаажуулалтын сан	Эрүүл мэндийн яам	Хариу өгөөгүй.	Дахин албан бичиг явуулсан.
6	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	Хөдөлмөрийн яам (урьд нь ХХААХҮЯ)		Хөдөлмөрийн яаманд шилжсэн тул дахин албан бичиг явуулсан.
7	Засгийн газрын нөөц сан	Сангийн яам	Тус сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн дүнг ирүүлсэн. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан, задаргаа байхгүй.	Хоёр удаа албан бичиг өгсөн болно.
8	Мал хамгаалах сан	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Тус сангийн маш товч танилцуулга өгсөн. Төсвийн ямар ч мэдээлэл байхгүй.	Гурван удаа албан бичиг өгсөн.
9	Нийгмийн	Нийгмийн	Мэдээлэл хүсээгүй.	

	даатгалын сан	даатгалын ерөнхий газар		
10	Нийгмийн халамжийн сан	Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар	Ирүүлээгүй.	Хоёрдахь албан бичгийг хүргүүлсэн.
11	Соёл, урлаг хөгжүүлэх сан	Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Соёл, урлагийг хөгжүүлэх сан	Тухайн хугацааны санхүүгийн тайлан, төсвийн хуваарилалтын нэгтгэлийг ирүүлсэн. Задаргаа байхгүй.	Дахин албан бичиг явуулсан.
12	Сургалтын төрийн сан	Сургалтын төрийн сан (БСШУЯ)	2012 оны сургалтын төрийн сангийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга ирүүлсэн. Задаргаа байхгүй.	Дахин албан бичиг явуулсан.
13	Тариаланг дэмжих сан	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	2011 ба 2012 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан өгсөн. Сангийн төсвийн зарцуулалтын задаргаа байхгүй.	Гурван удаа албан бичиг явуулсан.
14	Улсын авто замын сан	Зам, тээврийн яам	Хариу өгөөгүй.	Дахин албан бичиг явуулсан.
15	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан	Гадаад харилцааны яам	Хариу өгөөгүй .	Хүсэлт тавьсан.
16	Хүүхдийн төлөө сан	Хүүхдийн төлөө үндэсний газар	Хариу өгөөгүй.	Хүсэлт тавьсан.
17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	Хөдөлмөрийн яам	2012 оны эхний 8 сарын санхүүгийн тайлан, 8-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ ирүүлсэн. Төсөв хөрөнгийн зарцуулалтын задаргаа байхгүй.	Дахин албан бичиг явуулсан.
18	Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан	Сангийн яам	Тус сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн дүнг ирүүлсэн. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан, задаргаа байхгүй.	Хоёр удаа албан бичиг өгсөн болно.
19	Шинжлэх ухаан, технологийн сан	Шинжлэх ухаан технологийн сан (БШУЯ)	Хуулийн хугацаанд мэдээллийн эмхэтгэл өгсөн боловч тэдгээрт төсвийн мэдээлэл, задаргаа байхгүй .	Хоёр удаа албан бичиг явуулсан.
20	Эрүүл мэндийг дэмжих сан	Эрүүл мэндийн яам	Хариу өгөөгүй	Дахин албан бичиг явуулсан.
21	Сэргээгдэх эрчим хүчний сан	Эрчим хүчний яам	Сангийн журам, товч танилцуулгыг ирүүлсэн. Төсвийн зарцуулалт, задаргаа огт байхгүй.	Хоёр удаа албан бичиг явуулсан.
2	Олон улсын гэрээний дагуу байгуулагдсан сан		Мэдээлэл хүсээгүй.	

23	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	Хөдөлмөрийн яам (урьд нь БСШУЯ-нд хамаарч байсан)		Хөдөлмөрийн яаманд дахин албан бичиг явуулсан.
24	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	Батлан хамгаалах яам	Хариу өгөөгүй.	
25	Орон сууц хөгжүүлэх сан	Барилга, хот байгуулалтын яам	Товч танилцуулга ирүүлсэн.	Дахин албан бичиг явуулсан.
26	Хүний хөгжил сан	Сангийн яам	Мэдээлэл хүсээгүй.	
27	Төсвийн тогтворжуулалтын сан	Сангийн яам	Тус сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн дүнг ирүүлсэн. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан, задаргаа байхгүй.	Хоёр удаа албан бичиг өгсөн болно.
28	Цэвэр агаарын сан	Цэвэр агаарын сая (БОНХЯ)	Хуулийн хугацаанд мэдээлэл өгсөн боловч сангийн төсвийн зарцуулалт, задаргаа байхгүй	Хоёр удаа албан бичиг өгсөн.
29	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	Хууль зүйн яам	Сангийн үйл ажиллагаа эхлэл төдий байгаа ба нэг мэдээлэл өгсөн.	Хүсэлт тавьж мэдээлэл авсан.

Бидний хүссэн мэдээлэл буюу “төсөв хөрөнгийн орлого, зарцуулалтын тайланг төрийн бус байгууллага, судлаачид болон иргэд нягтлан үзэж дүгнэлт хийх боломж олгосон задаргаатайгаар” ирүүлэхийн оронд өргөн олон нийтэд төдийлөн ач холбогдолгүй санхүүгийн тайлангийн ямар нэгэн задаргаа, тайлбаргүй тоонуудыг ирүүлж байгаа нь мэдээллийн ил тод байдлын соёл төрийн яам, агентлагуудад тун хангалтгүй байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

Засгийн газрын тусгай сангуудын мэдээлэл, тэдгээрийг авах үйл явц болон авсан мэдээлэлд хийсэн дэлгэрэнгүй үнэлэлт, дүгнэлтийг “Иргэд төсвөө хянана” хэлэлцүүлгийн үр дүнд нэгтгэн гаргаж танилцуулах боломжтой.

2013.02.20.